САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

НАЙМДУГААР САР 2018

ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ДНБ
6.3%
2018 оны II-р улирлын байдлаар

ИНФЛЯЦИ
5%

ТӨГРӨГИЙН АМ.ДОЛЛАРТАЙ ХАРЬЦАХ ХАНШ
2464.12төг

ТӨСВИЙН АЛДАГДАЛ
410.8 тэрбум төг

ГАДААД ХУДАЛДАА
869 сая АМ.ДОЛЛАР

ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ
2.9 ТЭРБУМ ДОЛЛАР

ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ
8.5%

НИЙТ ХАДГАЛАМЖ
12 ИХ НАЯД ТӨГ

МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР
27.7 САЯ АМ.ДОЛЛАР

ГҮЙЛГЭЭНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ
927 ТЭРБУМ ТӨГ

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ
10%

ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +3.8%, 2019 онд: +4.3%
Инфляци: 2018 онд:+8%, 2019 онд +7%
Урсгал тэнцэл: 2018 онд ДНБ-ий -6.3%, 2019 онд: -7%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2018 оны тайланд тоймлосон байна.

Эх сурвалж: https://bit.ly/2HJFlip

ДНБ-ий өсөлт: 2018 онд: +5%, 2019 онд: +6.3%
Инфляци: 2018 онд: +6.4%, 2019 онд: +6.8%,
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2018 онд: -6.4%, 2019 онд: -8.3%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2018 он 4-р сар) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: http://bit.ly/2zsmvYo

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

Төсвийн тэнцэл 8-р сарын байдлаар 410 тэрбумын ашигтай гарав.

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 30.2 хувиар өсч, зарлага 7.1 хувиар өссөн бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 410 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 1 дахин буурсан байна..

Ам.долларын ханш өмнөх сараас 1 төгрөгөөр нэмэгдэв.

Наймдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 20 төгрөг буюу 0.8 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 1.29 төгрөг буюу 0.05 хувиар нэмэгдэж 2464.12 төгрөг болов. 7-р сард гадаад валютын нөөц 2.9 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 2 дахин буурсан байна.

Инфляцийн түвшин 5%

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2018 оны 8-р сарын байдлаар өмнөх сараас 0.8 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 5 хувиар, оны эхнээс 5.1 хувь өсөв. Тус сард ингэж өсөхөд хүнсний бараа, тээврийн хэрэгсэл, түлш, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ өсөхөд нөлөөлсөн байна.



Гадаад худалдааны тэнцэл 869 сая.ам доллар болов.

2018 оны наймдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 8473 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 23.5 хувиар өссөн бол экспорт 13 хувиар нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 38 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 869 сая ам.долларын ашигтай гарлаа.



8-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР



Эх сурвалж: МонголБанк

2018 оны хоёрдугаар улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 6.9 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 27.7 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 5 хувь (327.9 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 1% (167.3 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна.

Харин төв банкны өр өмнөх улирлаас өөрчлөлтгүй, хадгаламжийн байгууллагуудын өр -2% буюу 46 сая.ам доллараар буурчээ. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 8%-ийг Төв банкны өр, 8%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 29%-ийг бусад салбаруудын өр, 30%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

САРЫН ОНЦЛОХ: БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ББСБ-УУДЫН ХЭМЖЭЭ

- 2018 оны 8-р сарын байдлаар Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 24.8 хувиар, хувийн байгууллагынх 15.7 хувиар тус тус өсчээ. Түүнчлэн хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 206.3 тэрбум төгрөгөөр, чанаргүй зээл өмнөх сараас 13.2 тэрбум төгрөг буюу нэг хувиар өссөн байна. Чанаргүй зээлийн 82.2 хувийг хувийн байгууллагад олгосон зээл бүрдүүлж байгаа бол нийт хугацаа хэтэрсэн зээлийн 83.2 хувийг хувийн байгууллагынхны зээл бүрдүүлж байна. Мөн сард 46.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 629 иргэнд олгосон байна. Үүнээс орон нутагт 6.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 167 иргэнд олгожээ. Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 93 885 болсон байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.6 хувийг орон нутагт олгосон зээл эзэлж байна.

- ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ 1.14 их наяд төгрөгт хүрч харин даатгалын салбарын цэвэр ашиг буурсан үзүүлэлттэй байна. Үнэт цаас, даатгал, ББСБ болон хадгаламж, зээлийн хоршооны салбарын 2018 оны хоёрдугаар улирлын тайланд Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ энэ оны хоёрдугаар улиралд 65 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрчээ. Энэ нь 2017 оны жилийн эцсийн ДНБ-ий 9 хувьтай тэнцсэн байна. Өнөөдрийн байдлаар нийт 303 ХК, 54 үнэт цаасны компани тус зах зээлд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд ТОП-20 индекс өмнөх оны мөн үеэс 58.6 хувиар өсчээ.

Эх сурвалж:

1. *Статистикийн бюллетень, 8-р сар 2018 он, Үндэсний статистикийн хороо*
2. *Статистикийн бюллетень, 8-р сар 2018 он, Монголбанк*
3. *www.1212.mn, www.mongolbank.mn, www.montsame.mn,*